



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/761.

Булган сум

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чечень улсад зохион байгуулагдах Муслим Магомаевын нэрэмжит олон улсын VI дахь уралдаанд МУГЗЗ, Төрийн соёрхолт Н.Наранбаатарын нэрэмжит хөгжимт жүжгийн театрын дуучин Б.Гантөмөр, Н.Аззаяа нар шилдэг оролцогчоор шалгарч, улсаа төлөөлөн оролцох болсон тул замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Замын зардалд шаардагдах 6,900,000 (зургаан сая есөн зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын Уул уурхайн компаниудтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний санхүүжилтээс аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

